



Биелүүлэхийн Тулд Амладаг

ЭВ НЭГДЭЛ Бид бие биенээ хүндэлдэг.

Унших Зүйл

1 Самуел 20:14,15,42; 2 Самуел 4:4; 9:1-13, *Эцэг Өвгөд ба Зөнчид*, х. 713.

Цээжлэх Ишлэл

"Бид найзууд байна хэмээн Эзэн бидэнд амласан билээ" (1 Самуел 20:42).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Их Эзэн үргэлж амласан амлалтандаа хүрдэг гэдгийг **мэдэх** болно.
Амлалтандаа хүрэх хүсэл **эрмэлзэлтэй** болно.
Хийнэ гэж хэлсэнээ **хийдэг болох** болно.

Гол Санаа



Есүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Их Эзэний амласан ёсоор Давид Израилийн хаан болжээ. Нэгэн өдөр Давид түүний найз Ионатан өөрийнх нь төлөө ямар их сайныг үйлдсэнийг санаад Ионатаныг нэгэн хүүтэй болсныг мэдэв. Тэр хүүгийг нэр Мефибошет гэдэг ба Давид тэр хүүд Ионатаны газар болох хэсгийг өгчээ. Мөн Давид Мефибошетиийг өөрийн хамт амьдрахыг урьсан учир нь Давид Ионатанд хайртай байсан бөгөөд түүнийг хүндэлдэг. Бүх гэр бүлийнхэнд нь найрсаг байна гэж амласан байна.

Энэ бол эв нэгдлийн тухай хичээл

Давид Ионатан амласан амлалтандаа хүрсэн. Их Эзэн бидэнд амласан амлалтандаа үргэлж хүрдэг. Бид ч мөн амлавал түүндээ хүрэх хэрэгтэй.

Багшийн Баяжуулалт

"Хэн нэгний өгсөн амлалт нь - тухайн хүн амлалтаа биелүүлэхдээ ямар нэгэн буруу зүйлд хамаарагдахгүй л бол тэр нь ариун нандин зүйл болох юм. Хувиа хичээсэн байдал, өшөө авалт зэрэг нь хэн нэгний амлалт ам өчигт хэзээ ч

ДӨРӨВ

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1	Бэлтгэх Ажил	10 минут <i>А. Их Эзэн Нарыг Амласан</i> <i>Б. Бурханы Хууль</i>	цаасан таваг эсвэл дугуй цаас, шар өнгийн харандаа эсвэл тодруулагч, үдээсний машин эсвэл тууз цаас, өд, навч
*	Залбирал ба Магтаал*	10 минут 43-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2	Библийн Хичээл	20 минут Түүхтэй Танилцах Библи Судлал Цээжлэх Ишлэл	баяртай эсвэл гунигтай нүүр, Библийн тухайн үеийн том хүний болон хүүхдийн хувцас Библи Библи
3	Хичээлээ Заах	15 минут <i>Бурханы Амлалтууд</i>	Бурханы амлалтыг илэрхийлсэн зураг эсвэл эд зүйлс, цүнх эсвэл хайрцаг
4	Хичээлээ Хуваалцах нь	15 минут <i>Амлалтын Солонго</i>	цаасан зүлгүүр, нэхмэлийн утас, тодруулагч

нөлөөлж чадахгүй юм. (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 506).

"Давид, Ионатантай хийсэн амлалтынхаа дагуу Саулын гэр бүлд хор учруулахгүй гэжээ. Түүний хүнлэг байдал, амлалтаа санаж байгаа нь хааныг "Саулын гэр бүлээс хэн нэгэн үлдсэн үү? Би түүнд хүндэтгэл үзүүлэх" ёстой гэж чин сэтгэлээсээ асуусанд илэрч байна. Давидын дайснуудын мэдээлснээр Мефибошет Давидыг булаан эзлэгч хэмээн ихэд хорсон хилэгнэж байсан боловч хааны өгөөмөр нандин сэтгэл болон найрсаг

хүлээн авалт залуу хүүгийн зүрх сэтгэлийг ялан дийлсэн юм. (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 713).

Та амлалтандаа хүрч чаддаг уу? Хүүхдүүд харагдаж байгаа үлгэр жишээнээс суралцдаг. Хэрвээ томчууд нь амласнаа биелүүлдэггүй бол хүүхдүүдээс амлалтандаа хүрэхийг шаардах нь зохимжтой биш.

Өрөөний Зохион Байгуулалт

1-р хичээлийн тайзны засал болон 2-р хичээлийн "хааны өрөө"-г ашигла.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.



Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Их Эзэн Нарыг Амласан

Хэрэгтэй зүйлс:

- цаасан таваг эсвэл дугуй цаас
- шар өнгийн харандаа эсвэл тодруулагч
- үдээсний машин эсвэл тууз

Хоёр ширхэг цаасан таваг эсвэл дугуй цаасыг хүүхэд бүрт өгч тэднээр шар өнгөөр будуулаад гар багтах хэмжээ үлдээн хооронд нь ирмэгдүүлэн үднэ. Хэлэх: **Библид Их Эзэний хүн бүрт амласан амлалт бий. Матай 5:45-г харвал, Их Эзэн хүн бүрт зориулан мандах нарыг өгчээ. Өөрсдийн хийсэн наран дотроо гараа хийгээд дээш нь мандуулцаая. Одоо нар жаргаж буй мэт доош нь буулгацгаая. Өглөө болоход нар ахиад л манддаг. Нараа дээш нь өргөцгөөе. Шинэ өдөр ирлээ. Энэ үйлдлийг олон удаа давтаарай. Их Эзэн амлалтандаа хүрсэн байна уу?**

Бататгах нь

Асуух: Тэнгэр бүрхэг үед эсвэл бороо орж байхад юу болдог вэ? Их Эзэн амлалтаа мартсан уу? Үгүй ээ. Үүлний цаана нар гэрэлтсээр л байгаа. Хэдий бид харж чадахгүй байсан ч нар байж л байгаа. Их Эзэн амласан амлалтандаа үргэлж хүрдэг. Их Эзэн хийнэ гэж хэлсэн бүхнээ хийдэг гэдгийг мэдээд та нар юу мэдэрч байна вэ? Есүс хийнэ гэсэн зүйлээ заавал хийдэг бөгөөд Есүст хайртай хүмүүс амласан амлалтаа заавал биелүүлдэг. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол найз болох Ионатандаа амласан амлалтаа Давид хэрхэн биелүүлж байгаа тухай юм. Өнөөдрийн хичээлийн гол санаа:



Есүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Бурханы Хууль

Хэрэгтэй зүйлс:

- цаас
- өд
- навч

Хэлэх: Их Эзэн дэлхийг бүтээхдээ зарим зүйлийг үргэлж байна гэж хэлжээ. Түүний нэг бол татах хүч юм. Одоо энэ нь юу болохыг би та нарт харуулъя.

Бүгдээрээ босоод, чадах чинээгээрээ дээшээ үсэр. Бүх хүүхдүүдийг үсрүүлээрэй. Үсэрснийхээ дараа та нар агаарт тогтсон уу? Татах хүч та нарыг буулгалаа. Гэхдээ та нар хүнд шүү дээ. Тэгвэл бүгдээрээ хөнгөн зүйл дээр туршицгаая. Хүүхдүүдэд өд юмуу навч өгөөд агаарт

хийсгүүлээрэй. **Та нарын хийсгэсэн зүйл агаарт үлдсэн үү? Агаарт тогтож болох ямар нэгэн зүйлийг та нар мэдэх үү? Тийм ээ, шувуу, онгоц, эрвээхэй.**

Хүүхдүүдэд цаасан онгоц хийхэд нь туслаад нисгээрэй. Хэлэх: **Юу болсон бэ?** (агаарт удаан байсан ч буцаад буугаад ирсэн.) **Шувуу ч гэсэн ниссэнийхээ дараа бууж ирдэг шүү дээ. Их Эзэн амласан амлалтандаа хүрдэг. Тэр хийнэ гэсэн зүйлээ бүгдийг хийдэг.**

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Хэн нэгэн амласан амлалтандаа хүрэхгүй байвал та нарт ямар байдаг вэ? Хэн нэгэн амласан амлалтандаа хүрвэл та нарт ямар байх вэ? Их Эзэн амлалтандаа хүрдэг учраас би маш их баяртай байна. Есүст хайртай болон Есүс шиг байхыг хүсдэг хүмүүс амлалтандаа заавал хүрдэг юм. Чи ч мөн амласан амлалтандаа хүрэхийг хүсэж байна уу? Өнөөдрийн үзэх Библийн түүх бол найз болох Ионатандаа амласан амлалтандаа хүрч байгаа Давидын тухай юм. Санагтун:**



Есүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нохорлол

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

"Бурханы зам" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 259*)

"Миний зүрхэнд" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 195*)

"Бие биеэ хайрла" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 262*)

"Найзууд" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 256*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс тохирох түүх сонгож аваарай.

Хандив

Хэлэх: **Бид Есүс шиг байж чадна. Бидний өргөл бусдад туслах болно.**

Залбирал

Хэлэх: Амлалтандаа хүрдэгт нь Есүст талархъя. Амлалтандаа хүрдэг байхынхаа төлөө Есүсээс гуйцгаая.

* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- баяртай болон гунигтай нүүр
- Библийн тухайн үеийн хувцастай гурван том хүн болон хүүхдүүд
- суга таяг
- ятга орлох хатуу цаас
- Библийн тухайн үеийн нөмрөг

Юуны өмнө, хүүхэд бүрт зориулан хоёр дугуй цаасан дээр баяртай болон гунигтай нүүр хийж өгөөд хооронд нь наагаарай. Өгүүллэгийг унших явцад баяртай болон гунигтай үйл явдал гарвал тохируулан баяртай болон гунигтай нүүрээ гаргахыг хүүхдүүдэд хэлж өгнө. (Хэрвээ боломжтой бол баяртай болон гунигтай нүүр царайг хүүхдүүдээр хийлгээрэй.)

Зиба, Мефибошет болон Давидын дүрд тоглуулахаар 3 том хүн танд хэрэгтэй. Хүүхдүүд үйлчлэгч болох ба эсвэл хааны хэлсэн даалгаврыг биелүүлж болох юм. 2 саваа модоор суга таяг хийгээд Давид, Мефибошет болон Зибагийн дүрд тоглож байгаа хүмүүст хэлэх үгийг нь цаасан дээр хуулж өгөөрэй.

Давид: Өнөөдөр их сайхан өдөр байна. Би ятгаа авч хөгжимдөн дуу дуулмаар байна. [ятга авчрах]. Ямар сайхан ятга вэ. Энэ ч их удаж байгаа юм. Энэ ятга надад олон зүйлийг санагдуулдаг. Би хоньчин хүү байхдаа хөдөө гарч дуулдаг байсан юм. Энэ нь надад Саул хааныг санагдуулдаг юм. Тэр надад муу санадаг байсан болохоор тэр жилүүдийг санахаар **гунигтай** байдаг юм. [Хүүхдүүд гунигтай нүүр царайг өргөх.] Би түүнээс зугтаж нуугдах хэрэгтэй байсан. Одоо тэр цаг үе ард хоцорчээ. Гэхдээ би Саул хааны хүү Ионатан найзаа санахаар их **баяртай** байдаг. [Хүүхдүүд баяртай нүүр царайг өргөх.] Ионатан маш сайн найз байсан бөгөөд бид хамтдаа цагийг хөгжилтэй өнгөрөөдөг байсан юм. Бид хамтдаа хөгжилдөж, хамтдаа мориор давхиж [Хүүхдүүдтэй хамтран морьны төвөргөөн чимээ

гаргах], нум сум харваж [Харваж байгаа мэт чимээ гаргах], хамтдаа зоог барьдаг байлаа. Би Ионатаныг санаж байна. Түүнийг эцэгтэйгээ хамт байлдаж яваад амь үрэгдсэн гэж бодохоор надад их **гунигтай** байна [Хүүхдүүд гунигтай нүүр царайг өргөх.]

Би Ионатанд гэр бүлийг нь харж хандана гэж амласан юм байна шүү дээ. Түүний гэр бүлээс хэн нэгэн байдаг болов уу. Хэрвээ түүний гэр бүлийн хэн нэгэн одоо байдаг бол би их **баяртай** байх болно [Хүүхдүүд баяртай нүүр царайг өргөх.]

Үйлчлэгч нараа [Хүүхдүүд ирэх], Саулын үйлчлэгчийг олоод энд авчрагтун. [Хүүхдүүд Зибагийн дүрд тоглож байгаа хүнийг Давид дээр авчирна.]

Зиба: [толгойгоо бөхийлгөх] Та наймайг дуудсан уу, эрхэм ээ?

Давид: Тийм ээ, би дуудсан. Таныг хэн гэдэг вэ?

Зиба: Зиба гэдэг. Би Ионатаны гэрт үйлчлэгч хийдэг байсан юм.

Давид: Зиба, Ионатаны гэр бүлээс хэн нэгэн амьд байгаа болов уу? Би Ионатанд амласан амлалтандаа хүрч Их Эзэний хайрыг тэдэнд үзүүлэх болно.

Зиба: Тиймээ ноёнтоон, Ионатаны нэг хүү бий, түүний хөл гэмтсэн байгаа.

Давид: Би түүнтэй уулзмаар байна. Хэрвээ тэр амьд байвал би ихэд баярлах болно [Хүүхдүүд баяртай нүүр царайг өргөх.] Түүний хаа байгааг хэлээч. Би түүнийг ордондоо урмаар байна. Тусалсанд тань баярлалаа, Зиба. Одоо та явж болно. [Зиба явах.]

Давид: Үйлчлэгч нараа, Ионатаны хүүг над дээр авчир. Түүнд өөрсдийгөө Давидын үйлчлэгч гэдгийг хэлээд над дээр авчир. [Хүүхдүүд буланд сууж байгаа Мефибошетыг арчирах.]

Мефибошет: Та хэн бэ?

Үйлчлэгч нар: Бид Давид хааны үйлчлэгч нар байна.

Мефибошет: Та нарт юу хэрэгтэй вэ?

Үйлчлэгчид: Хаан таныг өргөөндөө урилаа.

Мефибошет: Би Давид хааны өргөөнд очих гэж үү? Та нар итгэлтэй байна уу? Би явахыг хүсэхгүй байна. Би айж байна. Миний өвөө Саул Давидад тийм ч сайн хандаагүй шүү дээ. Хаан намайг дуудсан учрыг та нар мэдэх үү?

Үйлчлэгч нар: *[толгойгоо сэгсрэх]*

Мефибошет: Аав минь энд байсан ч болоосой. Давид хаан аавтай минь их сайн найзууд байсан юм. Би Давид хаантай уулзахыг хүсэхгүй байна. Гэвч надад сонголт алга даа. Явцгаая. *[Үйлчлэгч нар Мефибошетэд туслан, тэр таягтайгаа хааны өргөөнд ирэх.]*

Давид: Та Ионатаны хүү юу? Таны нэрийг хэн гэдэг вэ?

Мефибошет: Тиймээ, Би Ионатаны хүү байна. Миний нэрийг Мефибошет гэдэг. Одоо би таны үйлчлэгч. *[Тэр хааны өмнө бөхийх.]*

Давид: Бос, Мефибошет. Өвөг эцгийнхээ надад хийсэн зүйлээс болж бүү **уйтгарла.** *[Хүүхдүүд гунигтай нүүр царайг өргөх.]* Тэр үе өнгөрсөн. Саул хааны эзэмшилд байсан газрыг би чамд өгөх гэсэн юм. Тэгээд мөн би чамайг ордонд надтай хамт амьдраасай гэж хүсэж байна.

Мефибошет: Та яагаад энэ бүгдийг хийж байгаа юм бэ?

Давид: Учир нь чиний аав Ионатан миний сайн найз байсан юм. Би эцэгт чинь гэр бүлийг нь харж хандах болно гэж амласан юм. Би амласан амлалтандаа хүрэхийг хүссэн учир чамайг дуудуулсан болой. Хэрвээ чамайг бидэнтэй хамт ордонд минь амьдарвал би маш их баяртай байх болно. *[Хүүхдүүд баяртай нүүр царайг өргөх.]* Үйлчлэгч нараа, *[Хүүхдүүд ирээд хааны өмнө бөхийх]* Зибга авчир *[Хүүхдүүд Зибга хаан дээр авчрах.]*

Давид: Зибга, Саул болон Ионатан нарт хамаарагдаж байсан бүх зүйлсийг би Мефибошетэд өглөө. Би чамайг

хүүхдүүдтэйгээ түүний үйлчлэгч болохыг хүсэж байна. Түүний газрыг арчлан үр тариаг ургуул. Гэхдээ Мефибошет надтай хамт ордонд амьдрах болно. Одоо чи явж болно.

Үйлчлэгч нараа, Мефибошетэд шинэ хувцас авчирч түүнд тусал. Тэр яг миний хүүгийн өмсдөг шиг хувцсыг өмсөх болно. *[Хүүхдүүд Мефибошетэд шинэ нөмрөг авчрах.]*

Үйлчлэгч нараа, Мефибошетэд шинэ өрөөг нь үзүүл. Мефибошет би чамтай оройн зоог дээр уулзая. Одооноос эхлэн, чи миний гэр бүлтэй хамт зоог барьж байгаарай. Би Эцэгт чинь амласан амлалтаа биелүүлэхэдээ **баяртай** байна. *[Хүүхдүүд баяртай нүүр царайг өргөх.]*

Мефибошет: Би ч мөн баяртай байна. *[Хүүхдүүд баяртай нүүр царайг өргөх.]*

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Мефибошетэд зориулан Давид ямар сайн зүйл хийсэн бэ? Давид Ионатанд амласан амлалтандаа хүрсэн үү? Хэн нэгэн чамд ямар нэгэн зүйл амлаад, амласан амлалтандаа хүрэхэд чамд ямар байдаг вэ? Хэн нэгэн чамд амласан амлалтандаа хүрэхгүй байвал чамд ямар байдаг вэ? Амласан амлалтандаа хүрэх амархан уу? Хийх боломжгүй ямар нэгэн зүйлээр чи амлалт өгч чадах уу? Амлалтандаа хүрэхэд хэн чамд туслах вэ? Санагтун:**



Ёсүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

Библи Судлал

Библи дэлгээд 1 Самуел 20:14, 15, 42; 2 Самуел 4:4, 9:1-13-р ишлэлүүдийг гаргаад хэлэх: **Бидний өнөөдрийн үзсэн түүх Бурханы үг болсон Библийн энэ хэсэгт бичээстэй байна.** Ишлэлүүдийг чанга уншиж өгөөрэй.

Хэрэгтэй зүйлс:

Библи

Бататгах нь

Асуух: Давид Ионатанд юу гэж амласан бэ? Ионатаны гэр бүлээс үлдсэн ганц хүн хэн байсан бэ? Түүний хөл яагаад гэмтсэн бэ? Давид Мефибошетын төлөө юу хийсэн бэ? Давид амлалтандаа хүрсэн үү? Чи амлалтандаа хүрэхийг хүсэж байна уу? Хэн үргэлж амласандаа хүрч чаддаг вэ? Амлалтандаа хүрэхэд чинь Есүс чамд тусалж чадах уу?



Есүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

Намайг дагаад хэлээрэй.

Цээжлэх Ишлэл

Библиэ нээгээд 1 Самуел 20:42-г гаргаад "Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна" гэж хэлээрэй. Ишлэлээ чангаар уншаад "Бид найзууд байна гэж Их

Эзэн бидэнд амласан билээ" гэж хэлнэ. Цээжлэх ишлэл дээр Ионатан Давидад найз байна гэж амладаг. Цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.



Бид Өөрийгөө заагаад бусдыг заах.



найзууд байна гэж Долоовор хуруугаа нийлүүлэх.



Эзэн Дээшээ заах.



бидэнд Өөрийгөө заагаад бусдыг заах.



амласан билээ. Баруун гараа зүрхэн дээрээ тавих.



1 Самуел 20:42 Алгаа ном мэт дэлгэнэ.

3

Хичээлээ Заах

Их Эзэний Амлалт

Юуны өмнө, бидэнд амласан Есүсийн амлалтыг илэрхийлэх зураг болон эд зүйлсийг цуглуулаарай. (биднийг хамгаалах, туслах, бороо оруулах, нарыг гэрэлтүүлэх, тэнгэр, дахин ирэлт, бороо гэх мэт). Хайрцаг эсвэл цүнхнээс хүүхэд бүрээр нэг зүйлийг авахуулж, тэр зүйл нь Их Эзэний ямар амлалтад хамаарах талаар ярилцаарай.

Хэрэгтэй зүйлс:

- Их Эзэний амлалтыг илэрхийлэх зураг ба эд зүйлс
- хайрцаг эсвэл цүнх

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж олгоорой: Энэ бүх амлалтуудыг сонсоод та нар юу мэдэрч байна вэ? (чухал гэдгийг нь, баяртай болох, гайхамшигтай). Есүс амлалтандаа хүрдэг гэдгийг яаж мэдэж болох вэ? (учир нь бид түүний амлалтаа

биелүүлснийг өдөр бүр хардаг Библид гардаг, учир нь тэр бидэнд хайртай юм). Есүс амлалтандаа хүрдэг болохоор би их баяртай байна, та нар ч бас баяртай байна уу?

Та нар ихэвчлэн юу амладаг вэ? Биелүүлэхэд үргэлж амархан байдаг уу? Та нарт хэн тусалж чадах вэ? (Есүс). Учир нь бидэнд амласандаа хүрэхэд тусална гэж амласан амлалтандаа Есүс үргэлж хүрдэг юм.

Та нар Есүс шиг байхыг хүсэж байна уу? Есүс шиг мөн Давид хэрхэн амлалтандаа хүрсэн шиг та нар ч мөн амлалтандаа хүрэхийг хүсэж байна уу? Санатгун:



Есүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

Намайг дагаад хэлээрэй.

4

Хичээлээ Хуваалцах нь

Амлалтын Бороо

Хүүхэд бүрт цаасан зүлгүүр өгч, адил хэмжээтэй солонгын долоон өнгийн цаас, нэхмэлийн утас бэлд.

Хэлэх: **Та нар солонгын долоон өнгөөр солонгын дүрс хий. Солонго нь Их Эзэний ямар амлалтыг та нарт санагдуулж байна вэ? Үүнийг хийж байхдаа, энэ долоо хоногт биелүүлэх ямар амлалт байгаагаа санацгаагаарай.**

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж олгоорой: **Энэ долоо хоногт биелүүлэх амлалтаа бодож олсон уу?** Солонго хийсэн цаасныхаа ард, амлалтаа бичихэд нь хүүхдүүдэд туслаарай. (Би тоглоомоо хураана, хаалга аяархан хааж байх болно, ах эгчтэйгээ тоглоомоо хуваалцана гэх мэт).

Хэлэх: **Их Эзэн амлалтандаа хүрдэг бас Тэр та нарт амласандаа хүрэхэд тусална гэдгийг энэ солонго та нарт**

сануулах болно.

Хийсэн солонгоо гэр рүүгээ авч яваад энэ долоо хоног хийсэн солонгоо хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Давид Ионатанд амласан амлалтандаа хэрхэн хүрсэн талаар хэлж өгөөрэй. Энэ долоо хоногт биелүүлэх амлалтыг чинь санахад солонго та нарт туслах болно. Энэ долоо хоногт та нар ямар амлалтаа биелүүлэх вэ?

Хүүхдүүд бичсэн амлалтаа дахин давтаж уншихад нь туслаарай.

Өнөөдрийн хичээлийн гол утга санаа:



Есүст хайртай хүн амлалтандаа хүрч чаддаг.

Намайг дагаад хэлээрэй.

(Adapted from Anita Reith Stohs, Little Hands Can Do [St. Louis, Mo: Concordia Publishing House, 1994], p. 12.)

Хэрэгтэй зүйлс:

- цаасан зүлгүүр
- нэхмэлийн утас
- хайч
- тодруулагч

Хичээлийн Хаалт

Их Эзэн амлалтандаа үргэлж хүрдэг болон амлалт хэрхэн чухал гэдгийг хүүхдүүд санаж байхын төлөө гуйгаарай. Амласан амлалтандаа хүрэхэд хүүхдүүдэд туслахын төлөө Их Эзэнээс гуйгаарай.

Биелүүлэхийн Тулд Амладаг

Унших Зүйл

1 Самуел
20:14,15,42; 2
Самуел 4:4; 9:1-
13, *Эцэг Өвгөд
ба Зөнчид*, х.
713.

Цээжлэх Ишлэл

"Бид найзууд
байна хэмээн
Эзэн бидэнд
амласан билээ"
(1 Самуел
20:42).

Гол Санаа

**Ёсуст хайртай хүн
амлалтандаа хүрч
чаддаг.**

Давид хаан хөх тэнгэр лүү хараад залуу насаа санажээ. Тэр хонь хариулж байсан үеэ, зөнч Самуел түүнийг хэрхэн тосолж Их Эзэний сонгогдсон дараагийн хаан болохыг нь хэлсэн тухай, Саул хаантай хамт амьдарч байснаа, Саул хааны хүү Ионатантай үерхэж байснаа ихэд санагалзав.

Давид санаа алдлаа. Ионатан дайнд амь үрэгдсэн. Давид түүнийг ихэд үгүйлжээ. Тэд хэрхэн морь унадаг байснаа, нум сум харвадаг байснаа, үргэлж найзууд байна гэж амласнаа санах. Гэнэт Ионатаны гэр бүлийг асран хамгаалах болно гэж хэлснээ ч бас саналаа.

Давид: *Одоо тэдний гэр бүлээс үлдсэн хэн нэгэн байдаг бол уу?* гэж бодоод Зибаг Саулын гэрийн үйлчлэгчийг дуудуулахаар явуулав. Зиба буцаж ирээд Саулын гэрээс нэг хүн үлджээ гэхэд "Давид түүнийг авчир, Би түүнд Их Эзэний хайрыг харуулъя" гэжээ. "Тийм ээ, Мефибошет багадаа хөлөө гэмтээсэн юм байна. Тэр Ионатаны хүү" гэж Зиба хэллээ.

Давид хаан инээмсэглээд "Би түүнийг хармаар байна" гэхэд хааны үйлчлэгч нар Мефибошетыг ордонд авчирав.

Давид хааны захиасыг сонсоод Мефибошет өөрийн өвөө Саулыг Давидад тун муу байсныг мэдэж байсан учир ихэд сандарчээ. Давид хаан яагаад түүнийг ордондоо урьсан юм бол? Хаан өөрийг нь хөнөөх гэж байгаа юм

бол уу? Тэр үгүй гэж хэлж чадахгүйгээ мэдэж байсан ч үнэхээр Давидтай уулзахыг хүссэнгүй.

Мефибошет ордонд ирээд хааны өмнө бөхийн ёслоод "Битаны үйлчлэгч" гэлээ. Давид хаан "Бүү ай. Танай аав Ионатан миний сайн найз байсан юм. Тийм учраас би чамайг

авчруулаа. Өмнө нь Саулын эзэмшилд байсан газрыг би чамд өгч байна. Тэгээд надтай хамт ордонд минь амьдраач" гэхэд Мефибошет ихэд гайхан "Та яагаад надад ийм сайн хандана вэ?" гэлээ. Хариуд нь Давид хаан "Яагаад гэвэл би аавд чинь хайртай байсан юм. Тэгээд түүнд гэр бүлийг нь асран хамгаална гэж амласан билээ" гэжээ.

Тэгээд Мефибошет ордонд нүүн ирж Давид ч түүнийг өөрийн хүү мэт хайрладаг болов. Удалгүй Давид Мефибошет хоёр сайн найзууд болжээ.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхийг уншаад цээжлэх ишлэлээ хамтдаа давтаарай.

Бид.....Өөрийгөө заагаад бусдыг заах.

найзууд байна гэжДолоовор хуруугаа нийлүүлэх.

Их Эзэн.....Дээшээ заах.

бидэнд.....Өөрийгөө заагаад бусдыг заах.

амласан билээ.....Баруун гараа зүрхэн дээрээ тавих.

1 Самуел 20:42.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

1 Самуел 20:14, 15, 42; 2 Самуел 4:4, 9:1-13-г уншаад "Ионатанд амласан амлалтандаа Давид хүрч чадсан уу?" гэж асуу.

Шаббат хичээл дээр хийсэн солонгоо энэ долоо хоногт хэн нэгэнтэй хуваалцаад түүнд Библийнхээ түүхийг хэлж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл шинээр солонго хийхэд нь хүүхдэдээ туслаарай, солонгын зураг ч зурж болно.)



Даваа

Шаббат хичээл дээр хийсэн хүүхдийнхээ амлалтын тухай ярилцаарай. Амлалт нь хэвээрээ байгаа юу? Яагаад?

Хэрвээ боломжтой бол, хуримынхаа зургийг хүүхдэдээ үзүүлэн хүмүүс Их Эзэнд юу гэж амласан болон хүмүүс гэрлэхдээ бие биедээ юу гэж амладаг тухай хүүхдэдээ хэлж өгөөрэй.

Мягмар

Татах хүчийг харуулахын тулд янз бүрийн жинтэй зүйлс хэрэглээрэй. "Энэ зүйлүүд яагаад дандаа унаад байна вэ? Их Эзэн татах хүчний тухай амласан амлалтандаа хүрсэн үү? Хэрвээ татах хүч байхгүй байсан бол яах вэ?" гэж асуугаарай.

Лхагва

Хүүхэдтэйгээ хамтдаа гадуур алхан Их Эзэний амласан зүйлүүдийг хараагаарай (нар, бороо, ургамал, солонго гэх мэт). Их Эзэний амлалтыг харуулж чадах өөр олон зүйлийн зурган цуглуулга хийгээрэй.



Пүрэв

Хүүхдэдээ ямар нэгэн зүйл амлаад түүнийгээ биелүүлээрэй. Матай 5:4-г уншаад "Энд Их Эзэн юу гэж амласан байна вэ? Өнөөдөр Их Эзэн амлалтаа биелүүлж байна уу? гэж асуугаад тэнгэр хэдий бүрхэг байсан ч нар гэрэлтсээр байгаа гэдгийг хэлж өгөөрэй.

Баасан

Гэр бүлийн залбирлын үеэр хүүхдээрээ хичээл дээр үзсэн түүхийг нь яриулаад *Эцэг өвгөд ба Зөнчид* номын 713-р хуудсыг хамтдаа уншаарай. Давидын гэр бүлтэй танайх юугаараа адил вэ?

Есүс дахин ирээд биднийг мөнх болгоно гэсэн амлалтын тухай ярицаад Түүний амлалтын тухай дуу дуулаарай.

Хэн нэгэн амлалтандаа хүрсэн ба хүрээгүй тухайгаа яриад тэр үед танд ямар байснаа хэлээрэй. "Амлалтаа биелүүлэх нь чухал уу?"

Амлалтынх нь төлөө Есүст талархаарай.